

Удирдлагын зүгээс иргэдтэй хийсэн уулзалтын тухай

2021 оны 09 дүгээр сарын 27

Улаанбаатар хот

Тус төвд хандсан иргэдтэй удирдлагын зүгээс сард 1 удаа уулзаж, тулгарч буй бэрхшээл, хүсэл зэмэлзэл, авахыг хүссэн үйлчилгээ, санал, хүсэлт, өргөдлийг хүлээн авч цаг алдалгүй шийдвэрлэж хариуг зохих журмын дагуу тухайн иргэнд өгч ажиллаж байна.

Шинэ төрлийн коронавирусийн халдварт өвчний үед иргэдийн өрөөнүүдэд уулзалт зохион байгуулж 2021 оны 3 дугаар улиралд 2 удаагийн уулзалтаар 07 дугаар сард 33, 09 дүгээр сард 46, нийт 79 иргэнтэй уулзаж санал сэтгэгдлийг нь сонсч үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлсэн.

Төвд үйлчлүүлэгч иргэдээс дараах санал, хүсэлтүүд ирдэг.

- Түр хоноглох байранд байрлах, байрнаас гарах, чөлөө авах
- Бичиг баримтын зөрчил арилгуулах, бичиг баримт шинээр болон дахин олгох
- Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах
- Нийгмийн халамжийн төрөл бүрийн үйлчилгээ гэх мэт.



ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН  Д. ГАНЗАЯА